



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ СУРГУУЛЬ



ОЛОН УЛСЫН
ХАРИЛЦАА


WORLD AFFAIRS

2009 №2 324 (19)



Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ СУРГУУЛЬ



ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

WORLD AFFAIRS

2009 №324 (19)



Улаанбаатар хот

DDC
327'015
O-295

Тус сэтгүүл нь анх 1996 оноос “Алтан аргамж” нэрээр, 2002 оноос “Олон улсын харилцаа” нэрээр гарч байна.

The journal has been published since 1996 as “Altan argamj” and since 2002 as “World Affairs”

Сэтгүүлийн зөвлөл:

Эрхлэгч:

Н.Алтанцэцэг (тэр.проф.доктор Ph.D)

Нарийн бичгийн дарга:

Д.Тунгалаг (проф.доктор Ph.D)

Гишүүд:

Ж.Баясах (тэр.проф.доктор Sc.D)
Ц.Гурбадам (проф.доктор Sc.D)
Д.Цолмон (тэр.проф.доктор Ph.D)
Б.Хулдорж (проф.доктор Ph.D)
Д.Намсрай (дэд проф.доктор Ph.D)
Д.Отгончимэг (дэд проф.доктор Ph.D)
Б.Энхбаяр (проф.доктор Ph.D)
Ж.Баттогтох (дэд проф.доктор Ph.D)

Хэвлэлийн эх бэлтгэсэн:

С.Оюунсүрэн
Б.Алтан-Өлзий

Сэтгүүлийн хаяг:

МУИС-ийн Олон улсын
харилцааны сургууль
Шуудангийн салбар – 46 а, хайрцаг-6
Улаанбаатар, Монгол улс
Утас: 354610; 354611; 354618
Факс: (976-11)354610
E-mail: muis_sfs@yahoo.com

Editorial Board:

Editor in Chief:

N.Altantsetseg (Prof.Ph.D)

Assistant Editor:

D.Tungalag (Prof.Ph.D)

Members:

J.Bayasakh (Prof. Sc.D)
Ts.Gurbadam (Prof. Sc.D)
D.Tsolmon (Prof.Ph.D)
B.Khuldorj (Prof.Ph.D)
D.Namsrai (Prof.Ph.D)
D.Otgonchimeg (Prof.Ph.D)
B.Ehkhbayar (Prof.Ph.D)
J.Battogtokh (Ph.D)

Publishing design:

S.Oyunsuren
B.Altan-Ulzii

Editorial Address:

School of Foreign Service
National University of Mongolia
P.O. – 46 a, Box-6
Ulaanbaatar, Mongolia
Tel: 354610; 354611; 354618
Fax: (976-11)354610
E-mail: muis_sfs@yahoo.com

ISBN 978-99962-53-08-9

ГАРЧИГ

I. Олон улсын харилцаа

Америк-Хятадын харилцааны зарим асуудалд	5
<i>А. Батцэцэг</i>	
Хятад улсын ирээдүйн талаарх таамаглал	9
<i>А. Батцэцэг</i>	
Дайн гарах шалтгаан: түүнийг судлах шинжилгээний гурван түвшин	13
<i>Д. Бүдсүрэн</i>	
Япон улсын ГЯЯ-ны сайд БНМАУ-д албан ёсны айлчлал анх хийсэн тухай	16
<i>Ц. Гүрбадам</i>	
Копенгаген сургуулийн аюулгүй байдлын онол	20
<i>Э. Өлзийлхам</i>	
Махатма Гандийн үзэл санаа орчин үе болон олон улсын харилцаанд холбогдох нь.....	30
<i>Д. Цолмон</i>	

II. Олон улсын эдийн засгийн харилцаа

БНСУ-ын гадаадаас авах ажиллах хүчний талаарх бодлого ба түүний чиг хандлага	35
<i>Л. Долгормаа</i>	
Гадаад худалдаанд тарифын бус зохицуулалтыг ашиглах нь	39
<i>П. Лхамсүрэн</i>	
Дэлхийн эдийн засгийн хямрал ба Монгол улс	43
<i>Д. Намсрай</i>	
Энэтхэгийн эдийн засгийн өсөлт, хөгжил	47
<i>Д. Отгончимэг</i>	
XX зууны сүүлийн хагас, XXI зууны эхэн үеийн олон улсын ажиллах хүчний шилжих хөдөлгөөний урсгал	51
<i>Д. Тунгалаг</i>	
Монгол-Японы эдийн засгийн хамтын ажиллагааг шинэ зуунд эрчимжүүлэх нь.....	57
<i>Б. Хулдорж</i>	
Монгол улсын газрын тосны бүтээгдэхүүний импортын хараат байдлыг бууруулахад БНХАУ-ын нөлөөлөх хүчин зүйл	67
<i>С. Энхцэцэг</i>	
Нөөц баялгийн хараал ба Монгол улс	83
<i>С. Энхцэцэг</i>	

III. Олон улсын эрх зүй

Шашин ба олон улсын эрх зүй	91
<i>Ж. Баттогтох</i>	
Олон улсын иргэний гүйлгээн дэх төрийн эрх зүйн байдал	97
<i>В. Оюумаа</i>	
“Монгол-Ойрадын цаазын бичиг”-ийн тухай	104
<i>Н. Улаан-Од</i>	
АНУ-ын эрүүгийн процесс дахь хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа (adjudication by plea)	108
<i>Ч. Хосбаяр</i>	

IV. Харьцуулсан хэл шинжлэл

Англи хэлний орчуулгын дадал хичээлд сонин хэвлэлийн материал ашиглахад анхаарах зүйл	117
<i>У. Лхагвасүрэн</i>	
Англи, монгол хэл дээрх эхнэр хүн, эмэгтэй хүний тухай зүйр цэцэн үгсийн тухай	120
<i>Л. Цэцгээ</i>	

АМЕРИК-ХЯТАДЫН ХАРИЛЦААНЫ ЗАРИМ АСУУДАЛД

А.Батцэцэг¹

Ө нөөдөр судлаачдын анхаарлыг зүй ёсоор Хятад, Америкийн харилцаа татаж байгаа билээ. Нэг талаас хамтын ажиллагаа, нөгөө талаас өрсөлдөөн энэ хоёр их айлын харилцааг тодорхойлж байна.

1972 оны 2 сард АНУ-ын ерөнхийлөгч Р.Никсоны БНХАУ-д хийсэн түүхэн айлчлалаар хоёр улсын харилцааг шинэ шатанд гаргасан “Шанхайн тунхаглал” батлагдан гарсан бөгөөд түүний шууд үр дагавраар хоёр улсын харилцаа хэвийн хэмжээнд очсон түүхтэй.² Тэр цагаас хойш өнөөдрийг хүртэлх хугацаанд Америк-Хятадын харилцаа олон улсын улс төрийн болоод эдийн засгийн нөхцөл байдалд чухал нөлөө үзүүлсээр ирэв. Энэ харилцаа түүхэнд хэдэнтээ зөөлөрч, хэдэнтээ царцан хүйтэрч байлаа.

Харин шинэ зууны хувьд шинэ асуудлууд хоёр талын харилцааг тодорхойлох болжээ. Улс төрийн байр суурийн ялгаатай байдал өсч байгаа нь зүй ёсоор харилцаанд үүсээд байгаа асуудлуудын нэг мөн. Тухайлбал, 2007 оны 10 сарын БНХАУ-ын КН-ын XVII их хурал дээр тус намын ТХ-ны ерөнхий нарийн бичгийн дарга Ху Жинтао “нэг улсын дангаар ноёрхлын эсрэг байгаагаа хатуу мэдэгдсэн³ бол өсөн нэмэгдэж байгаа “Хятадын аюул занал” нэрийн доор АНУ ч БНХАУ-аас илт болгоомжлох болсноо нуухгүй байна⁴. Эл хүрээнд хүний эрх ноцтой зөрчигдөж байгаа асуудал, Тайваний асуудал, Ази тив дэх Японы үүрэг хариуцлагын асуудлын талаарх харилцан зөрүүтэй байр суурийг дурдаж болно.

Нөгөө талаас хоёр талын харилцааны шинэ асуудал нь улам бүр хурдтай өсч байгаа эрчим хүчний хэрэглээ ба эрчим хүчний аюулгүй байдлаас үүдэн гарч байна.

БНХАУ-ын жил тутмын нефтийн хэрэглээний өсөлт 47%-д хүрээд байгаа бөгөөд 2022 он гэхэд тус улс өдөрт 21 сая баррель нефть хэрэглэх төлөвтэй байгаа нь хямралаас өмнөх АНУ-ын үзүүлэлт юм.⁵ Цаашид ч энэ асуудал улам хурцдах төлөвтэй байж болзошгүйг БНХАУ XVII их хурлаасаа 2020 он гэхэд бүх үзүүлэлтээрээ дэлхийд тэргүүлэгч эхний гурван улсын нэгт багтах, шинжлэх ухаан-технологийн ололтыг эдийн засгийн өсөлтөнд 65% хүртэл нэвтрүүлэх, өрсөлдөх чадвар болон мэдээлэлэлжүүлэлтээр дэлхийд тэргүүлэх 15 улсын нэгд багтах, үндэсний аюулгүй байдлын суурь болсон хүнс, эрчим хүч, экологи, цэвэр эрүүл ахуйн үзүүлэлтүүдийг бүрэн хангах зэрэг чухал зорилтуудыг тавьснаас харж болно.⁶

Мэдээж хоёр улсын харилцааны уламжлалт асуудал нь гадаад худалдаа буюу АНУ-д жил тутам Хятадтай хийх худалдаанаас учирч буй алдагдал юм. 1979 онд хоёр талын худалдааны эргэлт 2.5 млрд ам.доллар байсан бол 1995 онд 40.8 млрд, 2006 онд 262,7 млрд ам.доллар

¹ МУИС, ОУХС-ийн багш

² Д.Цолмон. АНУ-ын гадаад бодлогын түүх, дипломат ажиллагаа. УБ. 2005

³ В.Портяков. Основные итоги XVII съезда Коммунистической партии Китая. “Азия и Африка сегодня” №2, 2008.с.3

⁴ 2005 Report to Congress of the U.S. -China Economy and Security Review Commission- www.uscc.gov

⁵ А.Давыдов. США-КНР: партнерство или соперничество? . “Азия и Африка сегодня” № 6, 2008. с.6

⁶ A New Era?What to Make of the 17th Congress of the Chinese Communist Party-Carnegie Endowment for International Peace. Washington, D.C. October 24, 2007

хүрсэн.⁷ 2006 онд АНУ-ын гадаад худалдааны алдагдал 800 млрд ам.долларт хүрээд байсны 1/3 нь зөвхөн Хятадтай хийсэн худалдаанаас гарсан үзүүлэлт байв. БНХАУ-аас импортоор орж ирж байгаа хямд бүтээгдэхүүн нь санхүү эдийн засгийн хямралтай байгаа Америкийн мянга мянган ажилчдыг ажлын байргүй болгох эрсдэлийг өсгөж байгаа талаар ч мэдээлж байна.

АНУ-Хятадын харилцааны нэг том асуудал бол хоёр талын худалдааны тэнцэлд шууд нөлөөлж буй валютын ханш мөн. БНХАУ-ын юань уясан ханштай бөгөөд ханшийг сагсанд авсан валюттай харьцуулан тун бага өөрчилдөг. Зарим тохиолдолд юаний ханшийг удирдлагатай хөвөх ханш гэж тодорхойлох нь ч бий.⁸ Харин АНУ-ын доллар бусад улстай хийж буй худалдааны тэнцлээс шалтгаалж ханш нь өөрчлөгдөж байдаг чөлөөт хөвөх ханштай юм. Ханш тогтоох ийм зөрүүнээс болж хоёр улсын худалдааны тэнцэл АНУ-ын талд ашиггүй гарч байгаа нь хоёр улсын хооронд маргаан тарьж хоёр талын эдийн засгийн харилцааны нэг том асуудал болж байна. Жишээ нь, худалдааны асуудал дээр АНУ хатуухан байр суурь баримталж эхлэхэд хариуд нь Хятадын зүгээс валютын нөөцөөсөө их хэмжээний долларыг валютын зах дээр гаргаж ингэснээр ам.долларын ханшинд нөлөөлөх боломжтойг сануулдаг.⁹

Удаан хугацаанд Хятадын зүгээс юаний ам.долларт харьцах ханшийг өсгөхийг шаардаж ирсэн Америкийн шахалтыг анзаарахгүй байгаа мэт хандаж байгаад 2005 онд уясан ханшнаасаа татгалзсан хэдий ч бодит байдал дээр юаний ханш энэ хугацаанд зөвхөн 9 %-иар л өссөн байна. Хятадын Нийгмийн шинжлэх ухааны Академийн ажилтан Хэ Фань (He Fan) зөвхөн ам.долларын ханш хүчтэй унаж эхлэх үед л Хятад улс ам.доллараас салж чадна гэж мэдэгдсэнээс харахад тэртэй тэргүй түүхэндээ байхгүйгээр ханш нь унаад байгаа ам.долларын ханшны уналтаас болж худалдааны алдагдал улам ч өсөх хандлагатай байна¹⁰. Хятадын хувьд үндэсний валютын ханшаа тогтвортой доод түвшинд барьснаар дотоодын үйлдвэрлэгчиддээ олон давуу талыг олгож байдаг төдийгүй Хятадын бараа бүтээгдэхүүн зөвхөн дотоод төдийгүй гадаад зах зээл дээр өрсөлдөх чадвартай байх таатай боломжийг олгож байдаг. Хятадын компаниуд экспортыг доллараар үйлдвэрлэж, харин үйлдвэрлэлийн илүүдэл үлдэгдэл бүтээгдэхүүнийг юаниар өгдөг. Нөгөө талаас эл нөхцөл байдал нь Америкийн үйлдвэрлэгчдэд, ялангуяа Хятадын компаниудтай нүүр тулдаг салбарууд дээр өрсөлдөх чадварыг нь унагадаг. Ийм ч учраас ханшийн зөрүүтэй байдал АНУ-д таалагдахгүй байдаг юм.¹¹ Өөрөөр хэлбэл, АНУ-ын импортлогчид хямд юань худалдан авч, хямд бараа БНХАУ-аас татаж байгаагаас худалдааны алдагдалд орох боллоо. Энэ байдал АНУ-ын үндэсний үйлдвэрлэл, эдийн засагт хүчтэй цохилт болж уналтад нөлөөлж буй хүчин зүйл болж байгаа юм. Хоёр улс нийт 2007 онд 387 тэрбум ам.долларын худалдаа хийжээ. Ингэснээрээ Хятад улс Японоос илүү АНУ-ын хамгийн том экспортын зах зээл болж, Канадаас илүү хамгийн том импортын сурвалж болоод байна.¹² Хятад АНУ-ын нийт гадаад худалдааны 16,7%-ийг эзэлдэг бөгөөд гадаад худалдааны нийт алдагдлын 29%-ийг буюу бараг гуравны нэгийг нь бий болгодог.

Нөгөө талаас сүүлийн хорин жилийн турш АНУ-ын хуримтлалын ДНБ-дээ эзлэх жин аажмаар багасч байна. Нэг талаасаа АНУ-ын бүтээмжийн өсөлт өндөр, эдийн засгийн суурь хүчтэй тул хөрөнгө оруулалт их татаж байна. Нөгөө талаас, америкчуудын өрхийн хуримтлалын хэмжээ бага байдаг агаад засгийн газрын төсвийн алдагдал нийт хуримтлалын хэмжээг улам бүр бууруулж байгаа. Ялангуяа энэ үзүүлэлт хямралтай холбоотой хурдтай унаж байгаа нь олон судлаачдын сэтгэлийг зовоож байгаа юм.

Нэгэнт АНУ-д хуримтлал бага учраас гадаадын компаниуд өөрийн хуримтлалаа хөрөнгө оруулалт болгон АНУ руу юулж байгаагаас худалдааны алдагдал бий болж байна. Хятадын статистик мэдээллүүдээс харахад экспортын бараа бүтээгдэхүүн үйлвэрлэж байгаа

⁷ <http://news.mail.ru/politics/1409957/>

⁸ Labonte May 8, 2008, 2

⁹ Жишээ нь яг ийм нөхцөл байдал 2007 онд хоёр улсын хооронд өрнөж байсан хэлэлцээний үеэрх АНУ-ын байр суурийг зөөллөхөөр 1.3 трлн ам.доллар нөөцөөсөө гаргах Хятадын мэдэгдлээр үүсч байв.

¹⁰ <http://yefremov.110mb.com/FX-Magazine/2007/fm155.pdf>

¹¹ <http://lenta.ru>

¹² Labonte May 8, 2008, 5

үйлдвэрүүдийн талаас илүү хувь нь гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд байгаагаас олонх нь Хятадын хямд ажиллах хүчийг ашиглах зорилгоор байгуулагджээ. Тиймээс хөрөнгө оруулалтын өгөөж нь гадаадынхан руу урсдаг, компаниуд хөрш зэргэлдээ улсаас түүхий эдээ татаад Хятадад угсардаг байна. Үүний үр дүнд Хятад Тайвань, Өмнөд Солонгос, Япон зэрэг Зүүн Азийн хөрш орнуудтайгаа худалдааны алдагдалтай байдаг атлаа хэрэглээ өндөртэй АНУ зэрэг улстай худалдааны ашигтай болдог байна. Өөрөөр хэлбэл, АНУ-ын Хятадтай хийж буй худалдааны алдагдлын гол шалтгаан бол БНХАУ-ын хонжоо хайсан шударга бус худалдааны бодлого гэхээсээ илүүтэй Хятад өөрөө гадаадын компаниуд ашиг олох түшиц газар болж хувирсанд оршино.

Хоёр тал хоёул асуудлын мөн чанар ялгааг сайтар ойлгож байгаа нь дамжиггүй авч энэ асуудлыг шууд шийднэ гэдэг хэтэрхий амаргүй даваа юм. Юаний ханшийг тогтвортой байлгах нь Хятадын хувьд эдийн засгийн хөгжлийн асуудлаар зогсохгүй улс төрийн тогтвортой байдлын асуудал билээ. Тиймээс юанийг аажмаар чөлөөтэй хөвдөг болгох талаар ярьж байна. Гэтэл АНУ-д тийм удаан хүлээж суух цаг үнэндээ байхгүй, Хятадыг шударга бус наймаа хийж байна хэмээн шүүмжлэх нь л ихэсч байна.

Хятадын тал юаний ханшаа хөвүүлэхгүй, чангалахгүй байгаагийн шалтгаан бол экспортоо дэмжих гээд байгаад бус харин эдийн засгийн тогтвортой байдлаа юаний тогтвортой ханшаар дэмжихэд оршино гэж тайлбарладаг. Юаний ханшийг хөвдөг болговол Хятадын эдийн засагт үзүүлэх нөлөөг таамаглах аргагүй. Үйлдвэрийн дийлэнх нь экспортын чиглэлтэй учир хөвөх ханш руу шилжвэл тэдгээр үйлдвэр ашиггүй болж Хятадын эдийн засаг бүхэлдээ уналт, хямралд орож аюултай байгаа юм. Нөгөө талаар Хятадын банкны систем дорой бөгөөд хуралдсан өрийн сүлжээг зах зээлийн аргаар, чөлөөтэй хөвөх ханштай мөнгөөр барагдуулах боломж хомс байдаг. Хэрэв юаний ханшийг чөлөөлвөл ажилгүйдлийг нэмж, бага орлоготой үйлдвэрүүдийг сүйрүүлж, нийгэмд үймээн тарьж магадгүй юм. Улсын үйлдвэрийн газрын шинэчлэлийн үр дүнд ажилгүйдлийн тоо эрс нэмэгдэж, тэр хэрээр зарим хотод эсэргүүцэл гарах нь нэмэгдэж байгаа юм. Ийм хэсэгчилсэн шинэчлэл зарим газар ноцтой үр дагаварт хүргэж болзошгүй байтал юаний ханшийг чөлөөлвөл бүх эдийн засагт нөлөөлөх учраас бүр ч аюултай, эрсдэлтэй алхам болох нь дамжиггүй.

Гэхдээ БНХАУ-ын засгийн газар юанийг илүү уян хатан болгох дотоод эдийн засгийн шаардлага байгааг зөвшөөрч байна. Дотоодын хэрэглээг урамшуулах замаар алс хөдөөгийн амьдралыг сайжруулахад юаний хатуу ханш муу нөлөөлж байгааг Орчин үеийн улс төр судлалын Хятадын хүрээлэнгийн судлаач Лью Хонжунь дурдаад, цаашдаа хөвөх ханш руу орохоос өөр замгүй гэдгийг ч тэмдэглэжээ.¹³ Юутай ч БНХАУ юаний ханшийг аажимдаа чөлөөлөх бодлого барьж байна.

Харин АНУ удаан хугацааны туршид нэг л байр сууриа илэрхийлж ирсэн нь шударга худалдаа хийх сонирхолтой байгаад оршдог. Конгрессын олон гишүүн Хятадыг гадаад валют, тухайлан ам.доллар ихээр хуримтлуулж, Хятадын экспортыг юаний ханшаа сулруулах замаар дэмжиж байна хэмээн буруушааж байгаа юм. Одоо байгаа юань-долларын ханш зохист хэмжээнээсээ буюу юань чөлөөтэй хөвдөг байсан бол тогтох ёстой байсан зах зээлийн тэнцвэрт ханшаас даруй 15-40%, магадгүй түүнээс ч доогуур зохиомлоор тогтоогдсон гэж Америкийн зарим судлаачид үздэг. Хятадын юаний ийм бодлого тус орны хөгжлийн эхний шатанд зохимжтой байж болох авч өнөөгийн хэмжээ, дэлхийн эдийн засагт эзлэх Хятадын эдийн засгийн хэмжээг авч үзсэн ч хэтэрхий шударга бус байгааг АНУ-ын улс төрчид шүүмжилдэг¹⁴.

Өнөөдөр ам.долларын ханш суларч байгаа нь АНУ-д хөрөнгө оруулалт хийвэл ашигтай болгож байна. 2002 оноос хойш 25% унаад байгаа агаад жилд дундажаар 2,0-5,0% унаж байсан доллар 2007 оны 1 сараас 12 сар хүртэл 9% унаж хурдаслаа. Нөгөө талаар хятадууд АНУ-ын засгийн газрын бондыг ихээр худалдан авч төсвийн алдагдлыг нь нөхөж өгч байна. 2007 оны сүүлээр АНУ-ын засгийн газрын 406 тэр бум ам.долларын бондыг худалдан авснаараа Хятад

¹³ Lan May 1, 2008, 31

¹⁴ Ibid.,

Японы дараа орох хоёр дахь хамгийн том худалдан авагч болж, энэ хэмжээ 2008 оны 2 сар гэхэд 487 тэр бум ам.доллар хүрчээ.

Нийт дүндээ Хятадын юаний ханшаа "зохиомлоор" сул барьж байгаа явдал АНУ-ын эдийн засагт бүтцийн өөрчлөлт авчирч магадгүй гэсэн болгоомжлол судлаачдын дунд өндөр байна.

Юань-ам.долларын ханшийн асуудал манайд шууд хамаатай байж магадгүй юм. Учир нь бид худалдаагаа юаниар хийдэг атлаа хуримтлалаа ам.доллараар хийдэг. Тиймээс юаниар авсан барааныхаа үнийг ам.долларт шилжүүлж монгол төгрөгөөр зардаг. Эндээс монголчууд юань-долларын ханшийн зөрүүгээс шууд алдагдал хүлээж байгаа агаад магадгүй бараа бүтээгдэхүүний үнэ өсч буйн нэг шалтгаан байж болох юм. Түүнээс гадна юань-ам.долларын харьцаанаас хүлээж буй манай алдагдал үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломж өгөхгүй байгаа нэг шалтгаан ч байж болно. Юань-ам.долларын ханшийн зөрүү манай зах зээл дээр инфляц өсөхөд нөлөөлсөн томоохон хүчин зүйл болсон байж болзошгүй юм.

Манайд төгрөгийн юаньтай харьцах ханш сулрах явдал, ам.доллар юаньтай харьцах ханш сулрах явцтай адил шахуу байгаа үзэгдэл ажиглагдаж байгааг 2008 оны 12 сараас хойш тод ажиглаж болно. Тиймээс энэ асуудлыг Монгол улсын ашиг сонирхлын үүднээс нарийвчлан судлаж, цаашид манай улс хэрхэх талаар тодорхой шийдвэр гаргах хэрэгтэй байна.

АНУ – Хятадын худалдаа жил ирэх тусам өргөжин тэлж байгаа агаад өргөжих тусам энэ харилцаанд улам олон бэрхшээлтэй асуудал босч ирж байна. АНУ-ын Хятадтай хийх худалдааны алдагдал ихэсч, оюуны өмчийг хамгаалах талаарх Дэлхийн худалдааны байгууллагын шаардлагыг хангахгүй байгаагийн улмаас Америкт хэдэн тэр бумын хохирол учирч, АНУ-ын хувьд ашиггүй, хохиролтой олон төрлийн бодлого, үйл ажиллагаа авч хэрэгжүүлж байгаа байдал, АНУ-ын чанар стандартыг үл хангах бараа бүтээгдэхүүн нийлүүлж байгаа гэх мэт маш олон төрлийн асуудал байгаа юм. АНУ – Хятадын худалдаанд гарч байгаа эдгээр асуудал Хятадтай хийж байгаа манай худалдаанд ч адилхан тулгарч байгаа билээ.

Энэ хоёр улсын худалдааны харилцаанд гарч буй эдгээр асуудлаас манай улсад хамгийн ноцтой хамаарах асуудал бол магадгүй юань-ам.долларын харьцаанаас үүсч буй маргаан юм. Манай улс БНХАУ-тай юаниар худалдаа хийж, харин хуримтлалаа ам.доллараар хийдэг тул энэ хоёр валютын зөрүүнээс манай эдийн засаг алдагдал хүлээгээд байгаа эсэхийг магадлах шаардлагатай. Үндэсний үйлдвэрлэл хөгжиж чадахгүй байгаа, инфляц байнга тогтвортой өсөөд байгаагийн чухал нэгэн хүчин зүйл энд ч байж болох талтай тул анхаарал хандуулбал зохистой байна.